

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/172/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@auditgov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn Аудитор: Г.Ганбилэг Утас: 261628 Цахим хаяг: ganbilegg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.24 № 07/647
танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ
Б.НАРАНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу, хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 15,756.4 мянган төгрөгийн гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Өөрийн мэргэжилтнүүдтэй огноо дугаар байхгүй хүчин төгөлдөр бус гэрээ байгуулан ажлын хөлс нэрээр 53,972.8 мянган төгрөгийг олгосон;
- Гэрээ байгуулан 159,779.5 мянган төгрөгийн ажлын санхүүжилтийг бүрэн олгож зардлаар бүртгэсэн;
- Ажил гүйцэтгэх гэрээгээр 89,006.0 мянган төгрөгийн урьдчилж төлсөн тооцоог гүйцэтгэсэн ажлын тайлангүй зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Гэрээний хугацаа хэтэрсэн байхад 7,790.0 мянган төгрөгийн алданги тооцоогүй;
- Гадаад сургалтын зардалд батлагдсан төсвөөс 98,313.9 мянган төгрөгийг илүү олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/113 дугаар тушаалаар Эрүүл мэндийн яамны бүтцээс эрүүл мэндийн байгууллагуудын хэрэглэж байгаа программ хангамж, мэдээллийн технологи, аюулгүй байдлын бодлогыг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулах, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлэл технологийн 12 орон тоотой албыг шилжүүлж алуулснаар тус төвийн төсөв 1,521,578.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчний оношилгоо, эмчилгээг нутагшуулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2023 оны гадаад сургалтад хамруулах А/422 дугаар тушаалын хүрээнд тайлант онд 5 эмнэлгийн 37 эмч, мэргэжилтэн гадаадын 5 улсын их дээд сургуулийн эмнэлэг болон тэргүүлэх чиглэлийн эмнэлгүүдэд сургалтад хамруулсан байна.

Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй 273 маягыг 111 маягтад багтаан шинэчлэн загварчилж, статистик тайланг бодитой, богино хугацаанд гаргах боломжийг бүрдүүлж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдаар 8 үндсэн зорилтын хүрээнд 49 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр батлуулсан байна. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 97 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	670,580,883.36	1,103,901,889.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,326.48	0.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	18,326.48	0.00
31130	Нэмэлт санхүүжилт	18,326.48	0.00
32	АВЛАГА	74,985,359.00	385,000.00
335	Бусад авлага	74,985,359.00	385,000.00
33510	Байгууллагаас авах авлага	74,985,359.00	385,000.00
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	263,344,957.55	927,460,675.68
34600	Урьдчилж гарсан зардал	263,344,957.55	927,460,675.68
35	БАРАА МАТЕРИАЛ	332,232,240.33	176,056,213.43
351	Түүхий эд материал	27,385,100.00	4,919,000.00
35110	Тусгай зориулалттай материал	23,495,000.00	3,014,000.00
35130	Эм боох материал	3,890,100.00	1,905,000.00
354	Хангамжийн материал	304,847,140.33	171,137,213.43
35410	Бичиг хэргийн материал	39,841,960.00	17,082,460.00
35420	Аж ахуйн материал	8,040,338.00	7,942,044.00
35430	Сэлбэг хэрэгсэл	10,524,874.00	14,102,100.00
35440	Түлш, шатах тослох материал	901,697.56	2,517,403.66
35450	Барилгын засварын материал	7,616,100.00	7,688,500.00
35460	Хүнсний материал	1,350,000.00	5,681,500.00
35470	Бусад хангамжийн материал	236,572,170.77	116,123,205.77
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,839,541,477.54	4,234,216,467.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,839,541,477.54	4,234,216,467.97
392	Биет хөрөнгө	2,313,577,546.22	3,060,944,599.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,500,186,220.71	1,620,745,734.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(500,859,279.07)	600,901,354.87)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	167,824,185.00	323,624,185.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(67,480,607.32)	(99,279,638.23)
39205	Машин тоног төхөөрөмж	2,171,467,325.25	2,946,819,818.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,035,064,943.28)	(1,348,301,151.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	305,401,295.90	427,297,636.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(240,677,650.97)	(216,664,631.35)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,669,713.00	26,245,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,888,713.00)	(18,641,000.04)
393	Биет бус хөрөнгө	525,963,931.32	1,173,271,868.77
39301	Програм хангамж	652,519,698.55	1,443,386,605.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(232,826,927.23)	(376,385,896.23)
39303	Бусад биет бус хөрөнгө	106,271,160.00	106,271,160.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,510,122,360.90	5,338,118,357.08

СНАГ-2025/172/НА-СТА-ТШЗ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	22,678,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	22,678,400.00
413	Өглөг	0.00	22,678,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	22,678,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,510,122,360.90	5,315,439,957.08
51	Засгийн газрын хувь оролцоо	3,510,122,360.90	5,315,439,957.08
511	Засгийн газрын оруулсан капитал	2,390,485,153.08	2,390,485,153.08
51101	Өмч: - төрийн	2,390,485,153.08	2,390,485,153.08
512	Хуримтлагдсан үр дүн	255,166,876.53	2,060,484,472.71
51210	Өмнөх үеийн үр дүн	(151,909,581.25)	255,166,876.53
51220	Тайлант үеийн үр дүн	407,076,457.78	1,805,317,596.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	864,470,331.30	864,470,331.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,510,122,360.90	5,338,118,357.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	28,019,392,305.50	33,955,903,066.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,474,608,539.02	1,432,365,179.43
120	Нийтлэг татварын бус орлого	1,474,608,539.02	1,432,365,179.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	486,951,439.36	532,882,648.23
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	391,003,903.36	422,954,401.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,947,536.00	109,928,247.23
120009	Бусад орлого	8,360,000.00	13,680,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	971,964,013.94	884,826,745.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,333,085.72	975,786.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,544,783,766.48	32,523,537,887.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	25,179,787,300.00	31,609,856,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,179,787,300.00	31,609,856,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,364,996,466.48	913,681,087.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,364,996,466.48	413,296,087.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	500,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	385,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	27,612,385,847.72	32,137,542,054.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,612,385,847.72	32,137,542,054.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,293,122,011.69	31,491,162,169.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,264,893,433.70	22,196,009,778.13
210101	Үндсэн цалин	4,503,290,290.62	1,787,611,491.54

СНАГ-2025/172/НА-СТА-ТШЗ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210102	Нэмэгдэл	14,403,721,907.08	625,618,250.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	195,528,000.00	205,092,000.00
210104	Урамшуулал	162,353,236.00	240,940,660.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	19,336,747,376.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,617,757,347.37	2,669,763,878.61
210201	Тэтгэврийн даатгал	1,672,019,357.60	1,646,240,744.33
210202	Тэтгэмжийн даатгал	251,601,714.49	272,307,621.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	201,266,679.61	136,686,841.70
210204	Ажилгүйдлийн даатгал	55,342,699.63	135,455,528.83
210205	Эрүүл мэндийн даатгал	437,526,896.04	479,073,142.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,723,147.13	114,993,503.88
210301	Гэрэл, цахилгаан	63,051,957.57	61,077,220.59
210302	Түлш, халаалт	38,737,479.66	32,848,314.04
210303	Цэвэр, бохир ус	38,933,709.90	21,067,969.25
2104	Хангамж, бараа материалын зардал	559,446,513.99	160,043,475.54
210401	Бичиг хэрэг	10,235,050.00	13,195,900.00
210402	Тээвэр, шатахуун	12,032,278.00	11,832,901.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,982,536.59	13,599,082.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,599,444.00	84,592,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	122,836,820.50	15,393,372.00
210408	Бараа материал акталсны зардал	340,518,674.90	21,429,480.00
2105	Нормативт зардал	32,428,080.00	80,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,810,580.00	80,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,276,040.00	57,202,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,119,000.00
210604	Урсгал засвар	82,276,040.00	56,083,880.00
2107	Томилолт, зочны зардал	156,502,000.00	644,485,299.00
210702	Дотоод албан томилолт	156,502,000.00	644,485,299.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	840,201,515.09	1,272,662,812.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	773,220,484.09	1,228,174,803.45
210803	Даатгалын үйлчилгээ	196,020.00	106,920.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,633,100.00	27,222,136.00
210807	Газрын төлбөр	2,769,609.00	3,245,103.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	58,144,100.00	13,913,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,598,893,934.41	4,375,920,542.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,195,420.00	6,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,137,543,526.90	3,486,563,709.75
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	453,154,987.51	883,356,832.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,263,836.03	646,379,884.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,073,000.00	152,174,387.83
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,713,000.00	123,116,587.83
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,360,000.00	29,057,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	290,190,836.03	494,205,496.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	290,190,836.03	494,205,496.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	407,006,457.78	1,818,361,012.14

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	13,043,415.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	13,043,415.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0.00	(13,043,415.96)
5	НИЙТ ҮР ДҮН	407,006,457.78	1,805,317,596.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	27,039,545,205.84	33,070,100,535.23
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	494,761,439.36	546,562,648.23
Нийтлэг татварын бус орлого	494,761,439.36	546,562,648.23
Төсөв байгууллагын өөрийн орлого	486,401,439.36	532,882,648.23
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	384,538,903.36	422,854,401.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,862,536.00	110,028,247.23
Бусад орлого	8,360,000.00	13,680,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,544,783,766.48	32,523,537,887.00
Улсын төвлөрсөн төсвөөс	25,179,787,300.00	31,609,856,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,179,787,300.00	31,609,856,800.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,364,996,466.48	913,681,087.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,364,996,466.48	413,296,087.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	385,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	26,913,459,679.36	31,738,855,726.71
УРСГАЛ ЗАРДАЛ	26,913,459,679.36	31,738,855,726.71
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,594,195,843.33	31,091,825,342.39
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,252,551,303.27	22,018,817,717.40
Үндсэн цалин	4,534,808,347.96	1,479,617,211.83
Нэмэгдэл	14,384,603,255.31	638,159,685.94
Унаа хоолны хөнгөлөлт	163,112,000.00	215,055,515.50
Урамшуулал	170,027,700.00	218,656,283.27
Гэрээт ажлын хөлс	-	19,467,329,020.86
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,631,288,400.00	2,846,196,300.00
Тэтгэврийн даатгал	1,688,071,500.00	1,759,216,700.00
Тэтгэмжийн даатгал	251,279,200.00	270,099,500.00
ҮОМШӨ-ний даатгал	200,023,300.00	140,901,500.00
Ажилгүйдлийн даатгал	55,255,900.00	135,049,700.00
Эрүүл мэндийн даатгал	436,658,500.00	540,928,900.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,723,147.13	114,993,503.88
Гэрэл, цахилгаан	63,051,957.57	61,077,220.59
Түлш, халаалт	38,737,479.66	32,848,314.04

СНАГ-2025/172/НА-СТА-ТШЗ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Цэвэр, бохир ус	38,933,709.90	21,067,969.25
Хангамж, бараа материалын зардал	63,429,606.59	63,646,375.44
Бичиг хэрэг	9,812,600.00	10,940,800.00
Тээвэр, шатахуун	7,466,900.00	6,435,300.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,480,536.59	12,552,082.44
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,664,500.00	18,035,400.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,005,070.00	15,682,793.00
Нормативт зардал	5,816,400.00	1,048,500.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,318,800.00	1,048,500.00
Эд хогшил, урсгал засварын зардал	152,909,799.00	70,361,670.00
Багаж, техник, хэрэгсэл	1,488,000.00	18,209,090.00
Урсгал засвар	151,421,799.00	52,152,580.00
Томилолт, зочны зардал	157,848,800.00	650,833,426.00
Дотоод албан томилолт	157,848,800.00	650,833,426.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	835,931,233.23	1,478,348,523.56
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	804,720,302.23	1,273,426,014.56
Даатгалын үйлчилгээ	196,020.00	106,920.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,633,100.00	187,001,636.00
Газрын төлбөр	2,769,609.00	3,245,103.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22,374,000.00	14,568,850.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,353,697,154.11	3,847,579,326.11
Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,000,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,353,697,154.11	3,841,579,326.11
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,263,836.03	647,030,384.32
Бусад урсгал шилжүүлэг	29,073,000.00	152,439,887.83
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,713,000.00	123,116,587.83
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,360,000.00	29,323,300.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	290,190,836.03	494,590,496.49
Төвлөрүүлэх шилжүүлэг	290,190,836.03	494,590,496.49
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	126,085,526.48	1,331,244,808.52
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	70,000.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	126,137,200.00	1,331,263,135.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	126,137,200.00	1,331,263,135.00
Дотоод эх үүсвэрээр	126,137,200.00	1,331,263,135.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	126,137,200.00	1,331,263,135.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(126,067,200.00)	(1,331,263,135.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,326.48	(18,326.48)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,326.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СНАГ-2025/172/НА-СТА-ТШЗ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	(168,009,581.25)	3,086,945,903.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	16,100,000.00	16,100,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	(151,909,581.25)	3,103,045,903.12
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	407,076,457.78	407,076,457.78
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	255,166,876.53	3,510,122,360.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	255,166,876.53	3,510,122,360.90
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,805,317,596.18	1,805,317,596.18
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	2,060,484,472.71	5,315,439,957.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,451,752,600.0	31,648,534,451.7	803,218,148.3	97.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,451,752,600.0	31,648,534,451.7	803,218,148.3	97.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,312,867,600.0	31,509,774,563.9	803,093,036.1	97.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,428,284,700.0	22,018,817,717.4	409,466,982.6	98.2
210101	Үндсэн цалин	1,656,500,100.0	1,479,617,211.8	176,882,888.2	89.3
210102	Нэмэгдэл	488,355,000.0	638,159,685.9	(149,804,685.9)	130.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	239,940,900.0	215,055,515.5	24,885,384.5	89.6
210104	Урамшуулал	306,023,000.0	218,656,283.3	87,366,716.7	71.5
210105	Гэрээт ажлын хөлс	19,737,465,700.0	19,467,329,020.9	270,136,679.1	98.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,879,382,300.0	2,846,196,300.0	33,186,000.0	98.8
210201	Тэтгэврийн даатгал	1,792,402,700.0	1,759,216,700.0	33,186,000.0	98.1
210202	Тэтгэмжийн даатгал	270,099,500.0	270,099,500.0	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	140,901,500.0	140,901,500.0	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	135,049,700.0	135,049,700.0	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	540,928,900.0	540,928,900.0	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,714,800.0	114,993,503.9	28,721,296.1	80.0
210301	Гэрэл, цахилгаан	70,946,900.0	61,077,220.6	9,869,679.4	86.1
210302	Түлш, халаалт	34,802,600.0	32,848,314.0	1,954,286.0	94.4

СНАГ-2025/172/НА-СТА-ТШЗ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210303	Цэвэр, бохир ус	37,965,300.0	21,067,969.3	16,897,330.8	55.5
2104	Хангамж, бараа материалын зардал	64,789,600.0	63,646,375.4	1,143,224.6	98.2
210401	Бичиг хэрэг	10,941,000.0	10,940,800.0	200.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	6,435,300.0	6,435,300.0	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,612,100.0	12,552,082.4	1,060,017.6	92.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,118,000.0	18,035,400.0	82,600.0	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,683,200.0	15,682,793.0	407.0	100.0
2105	Нормативт зардал	1,048,500.0	1,048,500.0	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,048,500.0	1,048,500.0	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	586,409,300.0	569,218,805.0	17,190,495.0	97.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	322,099,900.0	314,304,970.0	7,794,930.0	97.6
210602	Тавилга	166,550,000.0	157,187,100.0	9,362,900.0	94.4
210604	Урсгал засвар	97,759,400.0	97,726,735.0	32,665.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	676,360,600.0	650,833,426.0	25,527,174.0	96.2
210702	Дотоод албан томилолт	676,360,600.0	650,833,426.0	25,527,174.0	96.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,363,140,000.0	2,233,918,523.6	129,221,476.4	94.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,875,938,500.0	1,761,190,014.6	114,748,485.4	93.9
210803	Даатгалын үйлчилгээ	107,000.0	106,920.0	80.0	99.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	455,831,100.0	454,807,636.0	1,023,464.0	99.8
210807	Газрын төлбөр	6,128,400.0	3,245,103.0	2,883,297.0	53.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,135,000.0	14,568,850.0	10,566,150.0	58.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,169,737,800.0	3,011,101,412.6	158,636,387.4	95.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,304,200.0	6,000,000.0	68,304,200.0	8.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,095,433,600.0	3,005,101,412.6	90,332,187.4	97.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,885,000.0	138,759,887.8	125,112.2	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,885,000.0	138,759,887.8	125,112.2	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,116,700.0	123,116,587.8	112.2	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,768,300.0	15,643,300.0	125,000.0	99.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,451,752,600.0	32,142,739,448.2	309,013,151.8	99.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,941,552,600.0	31,609,856,800.0	331,695,800.0	99.0
122005	Улсын төсвөөс санхүүжих	31,941,552,600.0	31,609,856,800.0	331,695,800.0	99.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	510,200,000.0	532,882,648.2	(22,682,648.2)	104.4
120004	Үндсэн үйл ажиллагааны орлого	410,200,000.0	422,854,401.0	(12,654,401.0)	103.1
120010	Туслах үйл ажиллагааны орлого	100,000,000.0	110,028,247.2	(10,028,247.2)	110.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	96	80	0.0	83.3
620001	Удирдах ажилтан	9	8	0.0	88.8
620002	Гүйцэтгэх ажилтан	87	72	0.0	82.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		913,699,413.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ		913,699,413.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		913,313,913.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,836,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,836,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		911,477,913.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		911,477,913.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		385,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		385,500.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		385,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		913,681,087.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		913,681,087.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		413,296,087.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		500,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		385,000.00

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 808,307.9 мянган төгрөгийн 3 алдаа¹ илрүүлж, аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 22,678.4 мянган төгрөгийн өглөгтэй боловч санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдлийг тайлагнаагүй, үлдэгдэлгүйгээр тооцоо нийлсэн.	1	22,678.4			1	22,678.4	1	22,678.4				
Тооцооны дансаар дамжуулаагүй 781,754.5 мянган төгрөгийн гүйлгээг харилцах данснаас шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	1	781,754.5			1	781,754.5	1	781,754.5				
Тэнгэр даатгал ХХК-тай 2024 оны 9 дүгээр сарын 6 ны өдөр тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ байгуулж, 3,875.0 мянган төгрөгийн төлбөрийг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	1	3,875.0			1	3,875.0	1	3,875.0				
Дүн	3	808,307.9			3	808,307.9	3	808,307.9				

3.2 Аудитаар нийт 1,713,792.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,263.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 981,077.0 мянган төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 730,451.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим эрүүл мэнд зөвлөлдөх уулзалт зохион байгуулах зардалд 3,556.5 мянган төгрөгийг бэлнээр зарцуулсан, зарлагын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	3,556.5			1	3,556.5						
Улсын гуравдугаар төв эмнэлэгт хэрэгжиж байгаа "Монгол улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал, телемедицин" МОН007 төслийн хүрээнд зүрх судасны тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх гол шалгуур үзүүлэлтийг боловсруулах, инфографик бэлтгэх, бүртгэл мэдээллийг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах" 49,725.9 мянган төгрөг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас "Хүн амын эрүүл мэндийн эрсдэл, эмзэг байдлын шинжилгээ, судалгааны статистик мэдээллийг боловсруулах" 19,171.9 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэх гэрээг ЭМХТ-тэй тус тус байгуулжээ. Уг ажлыг гүйцэтгүүлэхээр ЭМХТ нь Мэдээлэл технологийн албатай, тус алба нь өөрийн мэргэжилтнүүдтэй огноо дугаар байхгүй хүчин төгөлдөр бус гэрээ байгуулан мэдээлэл технологийн 23 ажилтанд ажлын хөлс нэрээр 53,972.8 мянган төгрөгийг олгосон байна.	1	53,972.8			1	53,972.8						

Дижиталмедик ХХК-д "Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан программын нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэх" 159,779.5 мянган төгрөгийн ажлыг он дамжуулан гүйцэтгэх /2024.12.20-2025.01.20/, урьдчилгаа санхүүжилт олгохгүйгээр гэрээ байгуулсан өдөр санхүүжилтийг 100 хувь өгөх нөхцөлтэйгөөр шууд гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгоод зардлаар бүртгэсэн.	1	159,779.5			1	159,779.5						
Блю ской инженеринг ХХК-тай программд нэмэлт өөрчлөлт оруулах үйлчилгээнд 39,406.0 мянган төгрөг, Өмгөөллийн цэцэн атторни ХХК-тай хуулийн зөвлөгөө авах 9,000.0 мянган төгрөг, 3 иргэнтэй зөвлөх үйлчилгээ авах 40,600.0 мянган төгрөг, нийт 89,006.0 мянган төгрөгийн гэрээг байгуулан гэрээг дүгнээгүй, ажлын тайлан ирүүлээгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	1	89,006.0			1	89,006.0						
"Олон улсын сувилагчдын баярын өдөр" чуулган зохион байгуулахад нийт 426,044.0 мянган төгрөг зарцуулсан. Үүнээс Уранган Палас ХХК -тай "Хоол хүнс,заал, танхим, тоног төхөөрөмж, хүлээн авалтын болон заал түрээсийн үйлчилгээ' авахаар 176,500.0 мянган төгрөг, Саунд ов монголиа ХХК-тай "Тайз засалт видео билэг хийх, зураг авалт, гэрэлтүүлэг хийх, арга хэмжээний зохион байгуулалт, найруулга интертайнтент үйлчилгээг бүрэн хариуцах"-аар 123,900.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулж зарцуулсан Мөн 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 170 дугаар нэмэлт ажил гүйцэтгэхээр 67,329.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж ЭМС-ын 2024 оны А/204 дүгээр тушаалаар баталсан төсөвт тусгагдаагүй зардал гаргасан, өөрийн чиг үүрэгт хамааралгүй ажилд хөрөнгө	1	367,729.0			1	367,729.0						

зарцуулсан зэргээр төсвийг үрэлгэн зарцуулсан.												
Эрүүл мэндийн багш, арга зүйч хөтөлбөрийг танилцуулах уулзалт зохион байгуулах зардалд 12,200.0 мянган төгрөгийг 2024 оны 12 сарын 04-ний өдөр Э.Мөнгөтулгад шилжүүлсэн боловч нь зарцуулалтын тайлангүй, анхан шатны баримт дутуу байна.	1	12,200.0			1	12,200.0						
Интер актив групп ХХК-аас Блю скай инженеринг ХХК-д олгосон хөгжүүлэгчийн эрх олгосон лиценз, сургалтад сууж хөгжүүлэх эрх авсан ажилтны сертификат, гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл, тендерийн баталгаа зэрэг бичиг баримтыг тендерийн материалд ирүүлээгүй байхад үнэлгээний хороо нь материалыг хангалттай гэж үзэж, нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг ашиглан "Эрүүл мэндийн статистик мэдээллийн 1313.mn системийн хөгжүүлэлт" хийх 250,000.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэгчээр Блю скай инженеринг ХХК-ийг сонгон шалгаруулж шууд гэрээ байгуулсан. Мөн үе шатны ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, ажлыг гүйцэтгэлийг комисс томилж хүлээж аваагүй, зөвхөн ЭМХТ-ийн мэдээлэл технологийн төвийн дарга хүлээн авч акт үйлдсэн.	1	0.0			1	0.0						
Монтех Дистрибьюшн ХХК-тай гэрээ байгуулж, 259,669.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн, гэрээний хугацаа 30 хоног хэтэрсэн байхад 7,790.0 мянган төгрөгийн алданги тооцоогүй	1	7,790.9			1	7,790.9						
ЭМХТ-ийн захирлын Гадаад сургалтад хамруулах 2024 оны А/114 дүгээр тушаалын дагуу БНСУ-д суралцахаар явсан 3 эмчид	1	5,490.2			1	5,490.2						

батлагдсан төсвөөс 5,490.2 мянган төгрөгийн онгоцны зардал илүү олгосон.												
ЭМС-ийн 2023 оны Гадаад сургалтад хамруулах А/422 дугаар тушаалыг үндэслэн Эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын сургалтад Эрүүл мэндийн байгууллагын 38 удирдах албан тушаалтан 2 мэргэжилтэн оролцуулж, 313,380.0 мянган төгрөгийг зарцуулж, баталсан төсвийн сургалтын зардлыг 91,230.5 мянган төгрөгөөр хэтрүүлж төсвийг үрэлгэн зарцуулсан, сургалт зохион байгуулсан "Soon chun Hyun" Их сургуулийн ангаахын төвтэй сургалтын төлбөрийн эцсийн тооцоог хийгээгүй, төсвийг үрэлгэн зарцуулсан	1	91,230.5			1	91,230.5						
Төлөвлөгөөнд тусгагдсан ч 2024 онд зохион байгуулагдаагүй гадаад сургалтын төлбөрт ЭХЭМҮТ-д 109,304.3 мянган төгрөгийг, ГССҮТ-д 81,017.3 мянган төгрөгийг нийт 190,321.6 мянган төгрөгийг шилжүүлж, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн.	1	190,321.6			1	190,321.6						
Гадаад сургалтад хамруулах ЭМС-ийн А/199 дүгээр тушаалын дагуу БНХАУ-ын Хөх хотод 1 дүгээр ээлжээр 36 бага эмчээр тооцож 12,402.4 мянган төгрөг шилжүүлээд яваагүй 2 бага эмчийн замын зардал 670.6 мянган төгрөгийн тооцоог Монголын төмөр замтай хийгээгүй	1	670.6	1	670.6								
ЭМХТ-ийн даргын 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар сургалтыг зохион байгуулагчаар 4 хүнийг томилон 21,284.0 мянган төгрөгийг олгосон, зохицуулагч нарын ачаа тээврийн зардалд 877.2 мянган төгрөгийг төсвөөс илүү төлсөн	1	877.2	1	877.2								
ЭМХТ-ийн даргын 2024 оны 10 дүгээр сарын 09-ны өдрийн А/123 дугаар тушаалын дагуу Шанхай хотод суралцахаар явсан 5 хүнд	1	716.0	1	716.0								

батлагдсан төсвөөс 716.0 мянган төгрөгийг илүү олгосон.												
Өмнө оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор ирүүлээгүй байна.	1	-					1	-				
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй 167 нэр төрлийн 730,451.9 мянган төгрөгийн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, шинэчлэн тогтоох үнийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.	1	730,451.9					1	730,451.9				
Дүн	16	1,713,792.7	3	2,263.8	11	981,077.0	2	730,451.9	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар 1 алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 гүйлгээний 64,000.0 мянган төгрөгийн зарлагыг оруулаагүй байна	1	64,000.0	1	64,000.0		
Дүн	1	64,000.0	1	64,000.0		